

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2015 оны 10 дугаар сарын

29-ний өдөр

Дугаар А/510

Хэрлэн

ЦАГИЙН ХЯЗГААРЫГ БАТЛАХ ТУХАЙ

М

онгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Цагийн хязгаарыг мөрдөж ажиллахыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгжийн захирал, дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нар болон аймгийн Цагдаагийн газар /П.Оростогоо/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ОЮУНБААТАР

Аймгийн Засаг даргын 2015 оны
10 дугаар сарын 09-ний өдрийн А/510
дугаар захирамжийн хавсралт

**Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй
худалдаа,
үйлчилгээний газрын цагийн хязгаар**

№	Худалдаа, үйлчилгээний нэр	Ажиллах цагийн хязгаар
1	Хүнсний дэлгүүр	09:00-21:00
2	Баар	11:00-00:00
3	Ресторан	08:00-01:00